



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠔ оны ᠐8 сарын 24 өдөр

Дугаар А/451

Номгон

Г Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төслийн Багц-2 Гүн өрмийн худаг, хашаажуулалтын ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд орон нутагт хийгдсэн гүн өрмийн худаг, хашаажуулалтын ажилд хяналт тавьж хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: П.Дашзэгвэ – “Баян өсөх агро” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Гишүүд: У.Балжинням- Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Т.Норовринчин - Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Дэд бүтэц, барилга, орон сууцны бодлого хариуцсан мэргэжилтэн

Тухайн сумдын Засаг дарга нар


Гүйцэтгэгч байгууллагын захирал

Нарийн бичгийн дарга: Т.Саранчимэг - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөдөө аж ахуйн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хэрэгжүүлсэн гүн өрмийн худаг, хашаажуулалтын ажлыг хүлээн авч илэрсэн зөрчлийн арилгуулах, техникийн бичиг баримтыг бүрдүүлж акт үйлдэж өмчлөлд бүртгүүлэн хүлээн авахыг ажлын хэсгийн дарга (Т.Хишигбаатар)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311155